



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2018 оны 10 сарын 30 өдөр

Дугаар 509

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1."Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 135,000,000.00 (нэг зуун гучин таван сая) төгрөгийн балансын үнэ, 90,000,000.00 (ерэн сая) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг "Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2.Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, "Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн гүйцэтгэх захирал Б.Отгонсүх, "Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Ц.Цэрэн нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Хөрөнгө хүлээлцэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3.Энэ тогтоолын биелэлтийг 2018 оны 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.

3.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.


ДАРГА

Ц.НЯМ-ОСОР

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН
ХЭЛТСИЙН ДАРГА

Б. ГАВАА





Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2018 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн
529 дугаар тогтоолын хавсралт

"Эгийн голын усан цахилгаан станц" төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компанийн балансаас
"Сэргээгдэх эрчим хүчний үндэсний төв" төрийн өмчит үйлдвэрийн газрын балансад шилжүүлэх хөрөнгө

Д/д	Автомашинны төрөл, зориулалт, улсын дугаар	Ашиглалтанд орсон он	Нийт гүйлт /км/	Нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэх өртөг (төгрөг)
1	"Ниссан патрол", суудлын, 61-89 УНА	2014	57,555.00	135,000,000.00	90,000,000.00	45,000,000.00
НИЙТ ДҮН:				135,000,000.00 (нэг зуун гучин таван сая)	90,000,000.00 (ерэн сая)	45,000,000.00 (дөчин таван сая)